

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Үнэт цаасыг бүртгэхээс татгалзах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.10.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Ваалюк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,100,000 ширхэг энгийн хувьцааг бүртгэхээс татгалзсугай.
2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ